

ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, НИЙТЛЭЛ

**ЗХУ-ЫН ШУА-ИЙН АЛС ДОРНОДЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
15 ЖИЛИЙН ОЙД**

Энэ онд ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэн байгуулагдсаны 15 жилийн ой болж байна. Анх байгуулагдах үедээ эрдмийн зэрэг цолтой 20-иод хүн, нийтдээ 50 хүрэхгүй ажилтантай байсан энэ хүрээлэн өнөөдөр 200 гаруй ажилтантай үүнээс доктор 17, дэд эрдэмтэн 104-тэй болж ЗХУ дахь хятад судлалыг тэргүүлэх томоохон төв болтлоо өргөжин хөгжсөн байна. Тус хүрээлэнгийн эрдэмтэд энэ богино хугацаанд асар их үр дүнтэй ажил хийж, ЗХУ-аар барахгүй дэлхий дахины хятад судлалын санд эрхэм чухал хувь нэмэр оруулж ирэв.

Хүрээлэнгийн хамт олон Ази, Алс-Дорнодын улс орнууд, түүний дотор БНХАУ-ын түүх, улс төр, эдийн засаг, үзэл суртал, соёлын асуудлаар онол эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой олон зуун бүтээл туурвисан нь ах дүү социалист орны эрдэмтэн, сэхээтэн дэлхий дахины дэвшилт олны шинжлэл судлалын үндэс суурь болж тэдний халуун талархлыг хүлээдэг болов.

Дэлхийн хувьсгалт хөдөлгөөнд жанжлах, улмаар даян дэлхийд ноёрхлоо тогтоох гэсэн хятадын өнөөгийн эрх баригчид ЗХУ болоод социалист бусад орнуудтай найрамдалт харилцааг тасалж, олон улсын империализм, харгис хүчийг илэрхий өөгшүүлэн дэмжих болсон 1960-аад оны эхнээс БНХАУ-ын гадаад дотоод бодлого, нийгэм эдийн засгийн байгуулалтын үндсийг бодитойгоор судлан дүгнэх явдал шаардагдсан юм. Их үндэстний дээрэнгүй жанжлан ноёрхох гадаад дотоод бодлого явуулах болсон Бээжингийн эрх баригчдын үйл ажиллагааг онол-түүхийн гүн гүнзгий үндэстэй марксист байр сууринаас илчлэн няцаах явдал дэлхийн энх тайван, аюулгүй байдал, Ази тивийн улс орнуудын хоорондын харилцаа, тэрчилэн хятадын ард түмний үндсэн эрх ашигт онцгой шаардагдсан чухам

ийм үед уг Хүрээлэн байгуулагдсан нь цаг үеэ олсон хэрэг байв. Өнгөрсөн хугацаанд уг Хүрээлэн Хятадын талаар хийсэн судалгааны ажлаа хятадын нийгэм-эдийн засаг, дотоод улс төрийн бодлого, БНХАУ-ын гадаад бодлого гэсэн гурван үндсэн чиглэлээр явуулж ирлээ.

Хүрээлэнгийн хамт олон хятадын нийгэм-эдийн засгийн үндсэн асуудлаар олон тооны хамтын болон ганц сэдэвт бүтээл тууривжээ.¹ Хятадын нийгмийн хөгжлийн бодит эүй тогтол, түүнд маогийнхнаас учруулсан саад тотгорын хор уршгийг задлан шинжилсний үндсэн дээр БНХАУ-ын нийгэм-эдийн засгийн байгууллын одоо ба ирээдүйн төлөвийн талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий зөв дүгнэлт хийсэнд уг бүтээлүүдийн ач холбогдол оршино.

Хятадын нийгэм эдийн засгийн хөгжилд аюул учруулсан Мао Зэдуны «Гурван улаан тугийн лоозон», «соёлын хувьсгал» мэтийн адал балмад үйлдал нь БНХАУ, хятадын нийт ард түмэнд нөхөж баршгүй гарз хохирол учруулсныг илчлэхэд Хүрээлэнгийн эрдэмтдийн гол бүтээл зориулагджээ. БНХАУ-ын аж үйлдвэр, хөдөө аж ахуй, машин үйлдвэрлэлт зэрэг сэдвээр олон тооны зохиолууд нийтлэгдэв.

Хятадын удирдлагын нийгэм эдийн засгийн алдаатай бодлого улам даамжирч, олон түмний ноцтой эсэргүүцэлтэй тулгарч эхэлсэн тул тэд бүх орон даяар цэрэг-хүнд суртлын диктатур тогтоож эхэлсэн билээ. Энэ тухай М. И. Сладковский, В. И. Акимов, А. П. Морозов нарын бүтээлд «Хятадын эрх баригчид марксизм-ленинизмийн зарчмаас тасран салж, улмаар адал балмад, их гүрний дээрэнгүй жанжлах бодлого явуулснаас болж 60-аад оны эхээр хятадын нийгэмд цэрэг-жүүлэх явдал

¹«БНХАУ-ын эдийн засаг» 4 боть. М., 1978, «БНХАУ-ын аж үйлдвэр», М., 1979, «БНХАУ-ын хөдөө аж ахуй» М., 1978, БНХАУ-ын эдийн засаг тээвэр, худалдаа, санхүү М., 1979, «Хятад өнөөдөр» М. 1969. В. И. Ванин. БНХАУ дахь улсын капитализм М. 1974, Е. А. Коновалов. БНХАУ дахь «их үсрэлт»-ийн бодлогын нийгэм эдийн засгийн хор уршиг. М. 1969. М. И. Сладковский, В. И. Акимов, А. П. Морозов БНХАУ үйлдвэржүүлэх асуудал ба зөрчил М., 1974, В. И. Акимов, А. П. Морозов. Бээжингийн цэрэг эдийн засгийн бэлтгэл М., 1976. М. И. Сладковский Хятад: түүх, эдийн засаг, үзэл суртлын үндсэн асуудал М., 1978. зэрэг олон арван номыг нэрлэж болно.

¹«БНХАУ-ын эдийн засаг» 4 боть. М., 1978, «БНХАУ-ын аж үйлдвэр», М., 1979, «БНХАУ-ын хөдөө аж ахуй» М., 1978, БНХАУ-ын эдийн засаг тээвэр, худалдаа, санхүү М., 1979, «Хятад өнөөдөр» М. 1969. В. И. Ванин. БНХАУ дахь улсын капитализм М. 1974, Е. А. Коновалов. БНХАУ дахь «их үсрэлт»-ийн бодлогын нийгэм эдийн засгийн хор уршиг. М. 1969. М. И. Сладковский, В. И. Акимов, А. П. Морозов БНХАУ үйлдвэржүүлэх асуудал ба зөрчил М., 1974, В. И. Акимов, А. П. Морозов. Бээжингийн цэрэг эдийн засгийн бэлтгэл М., 1976. М. И. Сладковский Хятад: түүх, эдийн засаг, үзэл суртлын үндсэн асуудалд М., 1978. зэрэг олон арван номыг нэрлэж болно.

эхэлж, одоо улам өргөн цар хүрээтэй явагдах болсныг онцлон тэмдэглэж энэ нь хятадын нийгэм эдийн засгийн бүтцийг үндсэнд нь эвдэж, миллиард хүн амын аж амьдралд аюул учруулж байна гэсэн бодит дүгнэлт хийсэн бөгөөд түүний үнэн зөв болохыг өнөөгийн хятадын үйл явдал бүх талаар гэрчлэн харуулж байна.

Хятадын аж үйлдвэр, түүний хөгжил, ажилчи анги тэднээс нийгэмд гүйцэтгэсэн үүрэг роль, тэрчлэн сүүлийн үеийн хятадын эдийн засгийн бодлого хөрөнгөтний зах зээл рүү чиглэх болсны учир шалтгаан зэргийн талаар онолын үндэстэй дүгнэлт хийсэн бүтээл цөөнгүй гарчээ.

Алс Дорнодын Хүрээлэн БНХАУ-ын дотоод улс төрийн байдлыг судлахдаа маогийн «соёлын хувьсгал» мэтийн олон удаагийн улс төрийн адал балмад кампаниуд хятадын хувьсгал, ард түмний эрх ашигт ямар их хор уршиг учруулсныг иш баримттайгаар харуулсан юм.

Судалгааны үр дүнд «соёлын хувьсгал» мэтийн адал балмад чиг шугам нь хятад дахь социалист хувьсгалыг багалзуурдан дарж, цэргийн харгис эргэлт хийх үндэс болсон гэдгийг илрүүлсэн байна. Тэрчлэн хятадын эрх баригчдаас ард түмнийхээ дотор явуулж байгаа дотоод улс төрийн бодлого, элдэв янзын улс төр үзэл суртлын кампаниуд болон хятадын хэвлэл мэдээллийн эх материалд тулгуурлан маоизмын ээлжит хямрал яаж явагдсан, цаашид хэрхэн үргэлжлэх, эцэстээ ямар байдалд хүрэх талаар урьдчилсан зөв зүйтэй судалгаа дүгнэлт цөөнгүй хийж эрдэм шинжилгээний чухал баримжаат төсөөлөл дэвшүүлсэн нь амьдрал практик дээр нотлогдсон билээ. Энэ нь тус Хүрээлэнгийн хамт олон асуудалд нягт нямбай, марксист байр сууринаас бодитой ханддаг болохыг харуулсан том үзүүлэлт мөн.

Тус Хүрээлэнгийн нэрт эрдэмтэд 1973 оноос эхлэн «Алс Дорнодын Асуудал» сэтгүүлийн «дугуй ширээ» хэмээх буланд Хятадын гадаад, дотоод улс төрийн болоод нийгэм-эдийн засгийн бодлогын талаар ярилцлага хийж өөрийн орны ба гадаадын хятад судлаач эрдэмтэд, өргөн олон уншигчидтай санал бодлоо хуваалцдаг болсон нь ихээхэн ач холбогдолтой болов.

Хүрээлэнгийн эрдэмтэд Мао Зэдунээс хойших үеийн БНХАУ-ын байр суурийн асуудлыг судлаж, ялангуяа хөрөнгөтний хятад судлаачдын гаргасан «Хятадад маоизмыг

өөрчилж байна» гэсэн дүгнэлтийг онолын үндэстэй шалган нягтлаад хятадын нийгэм-эдийн засаг, улс төр, үзэл суртлын бүх хүрээнд маоизм амь бөхтэй ноёрхож байгааг нотлон үзүүлээ.

Хятадын гадаад улс төрийн бодлогыг судлахад тус Хүрээлэн ихээхэн анхаарч ирсэн бөгөөд энэ талаар хийсэн судалгааны гол ажлууд нь «БНХАУ-ын улс төр, эдийн засаг, үзэл суртал» хэмээх жил тутам гардаг цуврал бүтээлийн гол үндэс нь болжээ. Мөн энэ талаар боловсруулсан нилээд бүрэн хэмжээний тогтолцоот үзэл нь «БНХАУ-ын гадаад бодлого олон улсын харилцаа» (М., 1974, I, II боть), «Маоизмын үзэл суртал-улс төрийн мөн чанар» (М. 1977) зэрэг олон тооны нэгэн сэдэвт зохиолуудад тусгагдсан юм.

Тус Хүрээлэн 1972 оноос эхлэн орос, англи, испани япон хэлээр «Алс Дорнодын асуудал» гэдэг эрдэм шинжилгээ, нийгэм улс төрийн сэтгүүл гаргах болсон нь Хүрээлэнг гадаадын олон уншигчидтай холбоод зогссонгүй, түүний нэр хүндийг хилийн чанадад ихээхэн өргөж өглөө. Сэтгүүлд социалист орнуудын хятад судлагч нэрт эрдэмтдийн бүтээл, мөн манай эрдэмтдийн олон тооны өгүүлэл нийтлэгдсэнийг тэмдэглэх хэрэгтэй. Өнгөрсөн 10 шахам жилд тус сэтгүүл хятад, японы холбогдолтой, тэрчлэн БНМАУ, БНСВУ-ын социалист байгуулалтын амжилт, ЗХУ ба социалист хамтын нөхөрлөл, дэлхийн бусад оронтой хятадаас харилцаж буй харилцаа, Бээжингийн их үндэстний дээрэнгүй бодлого, хятадын дотоод улс төр, эдийн засгийн байдал зэрэг олон тооны сэдэв хамарсан 4 мянга гаруй өгүүлэл нийтэлсэн байна.

Тус институтын эрдэмтэд социалист орнууд дахь хятад судлалын тивүүд, хятад судлаачидтай эрдэм шинжилгээний нягт харилцаа тогтоож хамтран ажиллаж ирэв. Түүний зэрэгцээгээр Европын Орнууд 1948 оноос эхлэн хийж, хожим улам өргөн хүрээтэй зохиогдох болсон хятад судлалын их хуралд 1956 оноос Зөвлөлтийн эрдэмтэд идэвхтэй оролцох болсон юм. Энэ их хурал 1976 онд Францад болж «Европын хятад судлалын холбоо»-г анх байгуулав. Алс Дорнодын хүрээлэн тус холбооны ажиллагаанд байнга идэвхтэй оролцож ирлээ.

1974 онд Алс Дорнодын Хүрээлэнд «гадаад харилцаа, олон улсын эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны хэлтэс» байгуу-

лагдсаны үр дүнд хүрээлэнгийн эрдэмтэд социалист орнуу-

дын эрдэмтэдтэй ажил тярлийн байнгын холбоогоо улам өргөн цар хүрээтэй болгов. Тэд хамтарсан судалгаа явуулах, хамтын бүтээл хэвлүүлэх эрдэм шинжилгээний ээлжит бага хурал, симпозиум зохиох зэргээр дээд хэмжээнд ажил төрлөө зохицуулан явуулдаг болов. Тухайлбал 1976 оноос хойш ах дүү социалист орнууд ээлжлэн жил бүр хятадын судлалаар олон улсын эрдэм шинжилгээний бага хурал симпозиум зохион явуулдаг болов. Ийм хурлын нэг нь 1979 онд Улаанбаатар хотноо зохиогдсон «Маоизм ба үндэстний асуудал» олон улсын симпозиум болно.

Тэрчилэн Хятадын шинэхэн түүхээр эрдэм шинжилгээний хурал жил бүр Москвад зохиогдож түүнд социалист орнуудын эрдэмтэд байнга оролцож ирлээ. 1979 онд «Маогийнхны түүх гуйвуулагчдын эсрэг», 1980 онд «Хөгжиж байгаа орнуудын талаар БНХАУ-ын бодлого», 1981 онд «ХКН-ын түүхэн туршлага» зэрэг эрдэм шинжилгээний хурлууд зохиогдсон бөгөөд хурлын материалыг ЗХУ ба бусад социалист орнууд хэвлэн нийтэлж байна 1980 онд БНБАУ, БНСВУ, БНАГУ, КУБА, БНМАУ, БНПАУ, ЗХУ, БНСЧСУ зэрэг ах дүү социалист 8 орны эрдэмтэд хамтран, «БНХАУ; Товч түүхэн найруулал» 1949-1979) номыг ЗХУ-д хэвлүүлэв. Уг номд БНХАУ байгуулагдсаны дараах 10-аад жилд улс төр нийгэм-эдийн засгийн хөгжилд, дэвшилт хандлага гарч байсан бол сүүлийн 20 жилд уг хандлага ухралтанд орж нийгэм-эдийн засгийн хөгжил зогсонги байдалд шилжсэнийг тодорхой баримтанд тулгуурлан онолын үндэстэй харуулсан байна.

Алс Дорнодын Хүрээлэнгийн хамт олон Монголын эрдэмтэдтэй хамтран «Үндэстний асуудлын талаархи маогийнхны бодлого», Болгарын эрдэмтэдтэй хамтран «Маоизмын хямрал үргэлжилж байна». БНАГУ-ын эрдэмтэдтэй хамтран «БНХАУ дахь анги, ангийн бүтэц» зэрэг хамтын бүтээлүүд гаргав. 1980 онд манай эрдэмтэд Алс Дорнодын Хүрээлэнтэй хамтран БНХАУ дахь Өвөр Монголын автономит район» номыг ЗХУ-д хэвлэн гаргалаа.* Уг номд Манж-хятадын дарлалын эсрэг Өвөр Монголын ард түмний олон үеийн тэмцлийг тусган харуулсны зэрэгцээ сүүлийн үед Бээжингийн эрх

Баригчдаас монгол үндэстний талаар явуулсан уусган хайлуулах бодлогыг бодит баримтаар илчлэн шүүмжилжээ.

ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын Хүрээлэн социалист орнуудын хятад судлалын төвүүдтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлж байгаа бас нэг жишээ бол тэдний ажилд туслах, тухайн орнуудаас аспирант болон дадлагажих ажилтнуудыг хүлээн авч мэргэжил дээшлүүлэх, суралцуулах ажил байнга зохиодог явдал болно. Тус Хүрээлэнд одоогийн байдлаар Болгар, Чехословак, Польш, Унгар, Монгол зэрэг орнуудаас аспирант суралцаж, цөөнгүй хүмүүс эрдмийн зэрэг хамгаалсан байна.

БНМАУ-ын ШУА-ийн Дорно дахины Судлалын Хүрээлэн Алс Дорнодын Хүрээлэнтэй ажил төрлийн нягт харилцаатай ажиллаж ирсэн нь манай ажилд үнэлж баршгүй тус болж байдаг юм.

Зөвлөлт-хятадын харилцаа тус Хүрээлэнгийн эрдэм судалгааны анхаарлын төвд байдаг томоохон асуудлын нэг юм.

Зөвлөлт-хятадын харилцааны түүх, бодит байдлыг гүн гүнзгий онолын үндэстэй задлан шинжилж бичсэн О. Б. Борисов. Б. Т. Колосков нарын «Зөвлөлт-хятадын харилцаа» (М., 1980 3 дахь удаагийн хэвлэл) онцгой байр эзэлнэ. Энэ ном 1973 онд Герман, Чехословакт, 1975 онд АНУ, Англид тус тус хэвлэгджээ. Уг ном монгол хэлээр 1979 онд хэвлэгджээ.

Өнгөрсөн 15 жилд тус институтын эрдэмтдийн боловсруулан тууригдсан олон талт нөр их ажил олон улсын империалист харгис хүч, түүний холбоотон Бээжингийн эрх баригчдаас хөрш зэргэлдээ Ази тивийн улс орнуудын эсрэг явуулж байгаа улс төрийн ба цэрэг-эдийн засаг, үзэл суртлын илэрхий дайсагнасан ажиллагааг марксист байр сууринаас онолын үндэстэй илчлэн няцаахад чиглэгдэж ирсэн нь дэлхий дахинд бат бэх энх тайван тогтоох, олон улсын харилцаанд эв найрамдлыг эрхэмлэх. Ази тивийн уур амьсгалыг намжаан зөөлрүүлэх, хятадын ард түмний үндсэн эрх ашгийг хамгаалахад үнэлж баршгүй ач тус үзүүлснийг 15 жилийн нь ойг тохиолдуулан тэмдэглэхэд таатай байна.

**О. Оюунгэрэл
М. Зэнээ**

*«Автономный район Внутренняя Монголия; Китайской Народной Республики» Изд-во «Науки» М. 1980. стр 156